



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЕСӨНЗҮЙЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 13/03

Есөнзүйл сум

Нийтийн сонсголын товыг
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 49 дүгээр зүйлийн 49.1, 49.3, 52 дугаар зүйлийн 52.1.4, 52.1.5 дахь заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ын 2.6 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит XIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.2022 оны сумын Засаг даргын Тамгын газрын төсөв, сумын 90 жилийн ойн хандивын зарцуулалт, гүйцэтгэлд хийх төсвийн хяналтын сонсголыг 2023 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 10 цагаас сумын Соёлын төвд зохион байгуулахаар товлон зарласугай.

2.Нийтийн сонсголын даргалагчаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч /Б.Цэцэгбадам/-ыг томилсугай.

3.Нийтийн сонсголын тухай хууль, нийтийн сонсголыг зохион байгуулах журмын дагуу бэлтгэл ажлыг ханган, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга /Т.Бат-Өлзий/, нийтийн сонсголыг тогтоосон цаг хугацаанд хууль, журмын өндөр түвшинд зохион байгуулж гарсан үр дүнг хагас жилийн хуралдаанд тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг /Б.Цэцэгбадам/ нарт үүрэг болгосугай.

4.Нийтийн сонсголын ажлын явц, үр дүн, хууль, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд байнга хяналт тавьж үүрэгжүүлж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Б.Мандах/-д даалгасугай.

ДАРГА  Б.МАНДАХ



My kom D: ITH Togtool

621521 031



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЕСӨНЗҮЙЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 13/04

Есөнзүйл сум

Нийтийн сонсгол зохион байгуулах, хяналт,
шалгалт хийх ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 52 дугаар зүйлийн 52.1.5, 52.1.7 дахь заалт, Нийтийн сонсголын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 9 дүгээр зүйлийн 9.3, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ын 2.6 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн сумын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн ээлжит XIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, хянан шалгах, нийтийн сонсгол зохион байгуулах, нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих ажлыг хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Цэцэгбадам – ИТХ-ын төлөөлөгч
Гишүүд: П.Амарзаяа – ИТХ-ын төлөөлөгч
Л.Пүрэвдулам – ИТХ-ын төлөөлөгч
В.Даваасүрэн – МЭТасгийн тархвар зүйч
Б.Мөнх-Очир – Хэсгийн цагдаа
Д.Ням – Иргэний төлөөлөл
Нарийн бичгийн дарга: Б.Бадамханд – ИТХ-ын төлөөлөгч

2.Ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хянан шалгах ажлыг зохион байгуулах, нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийтийн сонсгол зохион байгуулах, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах талаар удирдамж боловсруулан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг баримт, материалтай нь тулган шалгаж хийсэн ажлын тайлангаа сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанд хагас бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Цэцэгбадам)-д үүрэг болгосугай.

3.Хурлын дэргэдэх хяналт шалгалтын ажлын хэсгийг ажиллах бололцоо нөхцөлөөр ханган хууль журмын дагуу үүрэгжүүлж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Б.Мандах)-д даалгасугай.

ДАРГА  Б.МАНДАХ

621521 009
Му kom D: ITH Togtool

БАТЛАВ
ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
Б.МАНДАХ

2023 оны 04 дүгээр сарын 27 ны өдөр

НИЙТИЙН ХЯНАЛТЫН СОНСГОЛ ЗОХИОН
БАЙГУУЛАХ УДИРДАМЖ /ХӨТӨЛБӨР/

2023 оны 04 дүгээр сарын 27

Есөнзүйл сум

1.Зорилго – Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага “Нийтийн сонсголын тухай хууль”-ийн 8.3, 9.3 дахь заалт, ерөнхий хяналтын болон төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулах, Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулахад оршино.

2.Зорилт – Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид болон Засаг даргын Тамгын газрын төлөөлөл, иргэдэд Нийтийн сонсголын тухай хуулийн талаар мэдээлэл өгөх, сонсголыг хийж хэвшүүлэх

3.Зохион байгуулагч – Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, төлөөлөгчид, ажлын хэсэг

4.Хугацаа, байршил – 2023 оны 05 дугаар сарын 04-ны 10 цагаас сумын Соёлын төвд

5.Сонсголд оролцогчид – Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Албан байгууллага, аж ахуйн нэгж, Төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл /баг бүрийн иргэдийн төлөөлөл/ оролцоно.

6.Нийтийн сонсгол зохион байгуулах хөтөлбөр:

10:00 цагт – Сонсголд оролцогч, ажиглагчид, дуудагдсан албан тушаалтаныг бүртгэх /Ажлын хэсэг/

10:20 цагт - Нийтийн сонсголыг нээж үг хэлэх /ИТХ-ын дарга Б.Мандах/

10:30 цагт – Сонсголын сэдэв, хүсэлт, сонсгол зарласан огноо, сонсголд дуудагдсан албан тушаалтан, тайлбар хийх хүний нэр, оролцогчдын тоо, ажиглагчдын тоо, дэгийг уншиж танилцуулах /Сонсгол даргалагч/

10:40 цагт – Сонсголыг журам, дэгийн дагуу зохион байгуулах /Ажлын хэсэг/

1.Төсвийн мэдээллийг дуудагдсан албан тушаалтанаар оролцогчдод ойлгомжтой байдлаар хийлгэх

2.Мэдээлэлтэй холбоотой асуулт хариултыг журам, дэгийн дагуу явуулах

3.Мэдээлэлтэй холбоотой асуулт хариултыг таслах

4.Мэдээлэлтэй холбоотой санал дүгнэлтийг сонсох

5.Мэдээлэлтэй холбоотой санал дүгнэлтийг таслах

6.Нийтийн сонсгол зохион байгуулснаар оролцогчдоос гарсан шийдвэрийг ажлын хэсэг нэгтгэж тэмдэглэл хөтлөн иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хаягуудаар үнэн зөв мэдээлэлийг ажлын 5 хоногт багтаан иргэдэд мэдээлнэ.

14:40 цагт - Нийтийн сонсголыг хааж үг хэлэх /Сонсгол даргалагч/

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:НИЙТИЙН СОНСГОЛ

ДАРГАЛАГЧ

Б.Цэцэгбадам

Б.ЦЭЦЭГБАДАМ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20²³ оны
..0^у.. дүгээр сарын 0⁴..-ний өдрийн
хуралдаанаар батлав.

НИЙТИЙН СОНСГОЛЫН ДЭГ

Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан “Сонсголын нийтлэг журам”, Монгол Улсын Их хурлын 2017 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ын 4 дүгээр зүйлд заасны дагуу энэхүү дэгийг тогтоов.

Нийтийн сонсголд оролцож байгаа оролцогчид хууль, журмаас гадна энэхүү дэгийг дагаж мөрдөнө.

1.Нийтийн хяналтын сонсголыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас тогтоосон товын дагуу томилогдсон ажлын хэсэг журмын дагуу зохион байгуулна.

2.Хүндэтгэн үзэх шалтгаанаар нийтийн сонсголын товыг 1 удаа хойшлуулах мөн сонсгол даргалагчид хүндэтгэн үзэх шалтгаан гарсан тохиолдолд тухайн даргалагчаар томилогдсон этгээдийн санал болгосноор ажлын хэсгийн аль нэг гишүүн юм уу? иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөөс аль нэг нь сонсголыг удирдан явуулна.

3.Нийтийн сонсголын мэдээллийг урьдчилан 3-аас доошгүй хоногийн өмнө оролцогчдод тараан өгч танилцах боломж олгоно.

4.Нийтийн сонсгол явуулж байгаа сэдвээр сонсголд дуудагдсан албан тушаалтан 15-20 минутын хугацаанд оролцогчдод цаасаар болон дэлгэцээр мэдээлэл өгнө.

5.Сонсголд оролцохоор бүртгүүлсэн, хүсэлтээ ирүүлсэн иргэн, албан тушаалтан, мэргэжлийн холбоо болон төрийн бус байгууллагын төлөөлөл нь сонсголын танхимд ажлын хэсгээс ирүүлсэн дарааллын дагуу асуулт асууж, саналаа хэлнэ.

6.Сонсголд оролцогч 5 минут хүртэл хугацаанд багтаан үгээ хэлнэ

7.Хөгжлийн бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст үг хэлэх хугацааг өөрийн хүссэнээр сунгаж болно.

8.Асуулт, санал дүгнэлийг амаар гаргах боломжгүй бол бичгээр гаргаж ажлын хэсэгт хүргүүлнэ.

9.Бичгээр ирүүлсэн санал хүсэлтийг нийтийн сонсгол даргалагч танхимд уншиж танилцуулан хурлын тэмдэглэлд тусгуулна.

10.Санал, тайлбар, дүгнэлттэй холбогдуулан оролцогчдоос асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байна.

11.Асуулт хариулт дууссаны дараа санал, дүгнэлтээ сонсголд оролцогчдоос 2 минутаас илүүгүй хугацаанд хэлнэ.

12.Сонсголд оролцогч асуулт асуух, санал дүгнэлт хэлэхдээ сонсголын сэдвээс өөр сэдвээр үг хэлэхгүй.Өөр сэдвээр үг хэлсэн тохиолдолд сонсгол даргалагч үг хэлэхийг хязгаарлана.

13.Оролцогч нь сонсголын үеэр бусад оролцогч болон сонсгол даргалагчаас асуулт асуухгүй.

14.Сонсголд оролцогч бүдүүлэг үг хэлэх, бусдыг доромжлох, бусдын яриаг таслах, зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хашгирах, шүгэлдэх зэргээр бусдад саад учруулсан бол сонсгол зохион байгуулагч, даргалагчийн зүгээс шаардлага тавьж үл биелүүлсэн тохиолдолд ажлын хэсэг танхимаас гаргана.

НИЙТИЙН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл:

- 1.Энэ журмын зорилт нь ерөнхий хяналтын болон төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах үндэслэл, нарийвчилсан журам, сонсголын дэгийг тогтооход оршино.
- 2.Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага Нийтийн сонсголын тухай хуулийн 8.3, 9.3-т заасан ерөнхий хяналтын болон төсвийн хяналтын сонсголыг зохион байгуулахдаа энэ журмыг баримтална.

Хоёр.Нийтийн сонсгол зохион байгуулах үндэслэл:

- 1.Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах хүсэлтийг бичгээр гаргах бөгөөд хүсэлтэд сонсгол зохион байгуулах үндэслэл, шаардлагыг тодорхой заасан байх ба сэдэв, зорилго, товын талаархи саналаа тусгаж болно.
- 2.Хүсэлтийн дагуу сонсгол зохион байгуулах үндэслэл, шаардлагыг зохион байгуулагч, түүний ажлын алба хянан үзээд зохион байгуулах нь зүйтэй гэж үзвэл хариу мэдэгдэн сонсголд бэлтгэнэ.
- 3.Иргэн, хуулийн этгээд ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ирүүлсэн бол хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын таван өдөрт багтаан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Нийтийн сонсголын тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх, тухайн асуудлаар сонсголд зохион байгуулах эсэхийг хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв сонсголд зохион байгуулах шаардлагагүй гэж үзсэн бол үндэслэл бүхий хариуг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын гурван өдөрт багтаан бичгээр өгнө.
- 4.Засгийн газар, төрийн захиргааны төв, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага төсвийн хяналтын сонсголыг жилд нэг удаа өөрийн эрхлэх асуудал, хамаарах төсвийн хүрээнд зохион байгуулна.
- 5.Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах хугацааг товлон зарламагц тухайн асуудлаар төрийн аудитын байгууллагад дүгнэлт гаргуулахаар холбогдох баримт бичгийг хүргүүлнэ. Төрийн аудитын байгууллага гаргасан дүгнэлтээ сонсголд зохион байгуулахаас ажлын гурваас доошгүй өдрийн өмнө ирүүлнэ.
- 6.Ерөнхий хяналтын болон төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах тов, сэдэв, сонсгол даргалагчийг томилох асуудлыг Засгийн газар хуралдаанаараа, төрийн захиргааны төв байгууллагын хувьд сайд, нутгийн өөрөө удирдах байгууллагын хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, нутгийн захиргааны байгууллагын хувьд Засаг дарга тус тус шийдвэрлэнэ.
- 7.Сонсгол даргалагчийг томилохдоо сонсгол зохион байгуулах сэдвийг харгалзан тухайн асуудлаар мэргэшсэн, эсхүл туршлагатай, ашиг сонирхлын зөрчилгүй албан тушаалтныг сонгоно.

Гурав.Нийтийн сонсголын бэлтгэл хангах:

- 1.Сонсгол зохион байгуулагчаас сонсголын товыг тогтоосон бол товлосон өдрөөс хойш долоо хоногийн дотор Нийтийн сонсголын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан арга хэрэгслээр сонсгол явуулах огноо, цаг, сэдэв, байр, ажиглагчаар оролцох хүний тоо, оролцогчдыг хэрхэн бүртгэх, бүртгэл дуусах хугацааны талаар нийтэд мэдээлнэ.

бол Төрийн албаны тухай хуулийн 15.1.16-д заасан, нийтийн сонсголыг зохион байгуулах, сонсголд оролцох журмыг зөрчсөн гэж үзнэ.

Дөрөв.Нийтийн сонсгол зохион байгуулах:

1.Сонсгол даргалагч сонсголын сэдэв, хүсэлт, сонсгол зарласан огноо, сонсголд дуудагдсан албан тушаалтан, холбогдох этгээд, шинжээч, тайлбар хийх хүний нэр, сонсголд оролцогчдын тоо, сонсголын дэг зэргийг 10 минутад багтаан танилцуулна.

2.Сонсгол зохион байгуулах хүсэлт гаргасан этгээд, эсхүл тэдгээрийн төлөөлөгч хүсэлтийнхээ үндэслэл, шаардлагын талаар 10 минутад багтаан танилцуулна.

3.Сонсголд оролцогч санал хэлэх, тайлбар, дүгнэлт гаргах дарааллыг сонсгол даргалагч тогтоох ба оролцогчид сонсголын танхимд ирсэн хугацааны дагуу санал хэлэх эрхийг олгож болно. Дарааллыг тогтоохдоо эерэг болон эсрэг саналтай, олонхи болон цөөнхийн төлөөллийг оролцуулах зарчим баримтална.

4.Ажиглагч нь сонсголын үед асуулт асуух, үг хэлэх эрх эдлэхгүй.

5.Сонсголд оролцогчийн үг хэлэх хугацааг 3-10 минутаар тогтооно.

6.Хөгжлийн бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүст үг хэлэх хугацааг шаардлагатай хэмжээгээр сунгаж олгоно.

7.Мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөлөл сонсголд оролцохдоо бусад оролцогчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

8.Санал, тайлбар, дүгнэлттэй холбогдуулан оролцогчоос асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байна.

9.Асуулт, хариулт дууссаны дараа сонсголд оролцогчид болон хүсэлт гаргасан төлөөлөл санал, дүгнэлтээ оролцогчдын тооноос хамааран 1-3 минутын хугацаанд хэлнэ.

10.Асуулт асуух, үг хэлэхдээ сонсголын сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сонсгол даргалагч асуулт асуух, үг хэлэхийг хязгаарлаж болно.

11.Сонсголд оролцогч бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, бусдын яриаг таслах, зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хашгирах, шүгэлдэх зэргээр бусдад үгээ чөлөөтэй хэлэхэд саад учруулсан болон сонсгол зохион байгуулагч, сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзвал сонсгол даргалагчид дэг баримтлахыг шаардаж, шаардлагыг үл биелүүлбэл ажлын алба оролцогчийг танхимаас гаргаж болно.

12.Сонсгол даргалагч сонсголыг хааж үг хэлнэ.

13.Ажлын алба сонсголын тэмдэглэлийг аудио болон бичгэн /товч/ хэлбэрээр хийж тухайн байгууллагын албан 2 / 3 ёсны цахим хуудсанд ажлын таван өдрийн дотор байршуулна.

14.Сонсгол дууссаны дараа сонсголын үйл ажиллагаа болон сонсголын үед хэлэлцэгдсэн асуудал, асуулт, хариулт, мэдээлэл, дүгнэлт зэрэгтэй холбогдуулан ямар нэгэн зарга, гомдол үүсгэхгүй ба ямар нэгэн арга хэмжээ авагдахгүй.

ТӨСВИЙН ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ҮЙЛ ЯВЦ

Танилцуулга: Сонсголын эхэнд даргалагч өөрийгөө болн сонсгол зохион байгуулагч байгууллагын төлөөлөл, сонсголын сэдэв, сонсголд дуудагдсан албан тушаалтан, үг хэлж тайлбар хийх иргэд, бусад оролцогчдын тоо, сонсголын дэгийг 10 минутанд багтаан танилцуулна.

Сонсгол зохион байгуулах үндэслэлээ танилцуулах: Хэрвээ төсвийн хяналтын сонсголыг төсвийн тодорхой сэдэв, асуудлын хүрээнд зохион байгуулах санал гаргасан этгээд байгаа бол тэдний төлөөлөл хүсэлтийнхээ үндэслэл шаардлагын талаар 10 минутанд багтаан танилцуулна.

Дэг тогтоох: Сонсгол даргалагч үг хэлэхээр бүртгүүлсэн хүн тус бүрийн үг хэлэх дарааллыг тогтооно. Дарааллыг тогтоохдоо няцаах, хамгаалах, эсвэл эсрэг, эерэг саналуудыг ээлжлэн сонсох зарчмыг баримтлана. Оролцогчийн үг хэлэх хугацааг 3-10 минутын хооронд тогтооно.

Үг хэлэх: Сонсголд оролцож үг хэлэхээр бүртгүүлсэн иргэн, дуудагдсан албан тушаалтан үнэн бодитой, баталгаа, нотолгоотой тайлбар мэдээлэл өгөх үүрэгтэй. Жишээ нь: Засаг даргын Тамгын газрын төсвийн гүйцэтгэл, зарцуулалт, сумын 90 жилийн ойн хандив, гүйцэтгэл, зарцуулалтыг аудит, мониторинг хийсэн дүн, илгэрсэн зөрчил байвал/ тоо, баримтын хамт танилцуулга хийхдээ оролцогчдод тодорхой дэлгэцээр дэлгэрэнгүй харуулна.

Асуулт асуух: Оролцогч, дуудагдсан албан тушаалтан танилцуулга, тайлбар хийсний дараа Сонсгол даргалагч эсвэл сонсох ажиллагаа явуулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нар асуулт асууна. Асуулт асуух хугацаа 4 хүртэл минут, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минут байна.

Санал дүгнэлт хэлэх: Асуулт хариулт дууссаны дараа үг хэлсэн иргэн санал дүгнэлтээ 1-3 минутанд багтаан хэлэх эрхтэй. Санал дүгнэлтээ урьдчилан бичгээр өгч болно.

Сонсголд дуудагдсан албан тушаалтанаас мэдээлэл авах: Төсвийн хяналт хийж үг хэлсэн иргэний танилцуулгатай холбоотой холбогдох албан тушаалтанаас нэмэлт мэдээлэл авч, асуулт асууна. /Ойлгомжгүй, тодорхой бус асуудлаар/

Хуулийн этгээдийн мэдүүлэг: Шаардлагатай гэж үзвэл тухайн төсвийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ гүйцэтгэгч аж ахуйн нэгж, харилцагч этгээдийн төлөөллөөс мэдүүлэг авч тодруулна.

Сонсголыг хаах: Сонсгол даргалагч сонсголыг хаана. Сонсголын үед ямар нэгэн шийдвэр гардаггүй гэдгийг анхаарна уу? Гэхдээ сонсох ажиллагааны үр дүн цаашид хийх ажлыг товч танилцуулж болно. Жишээ нь: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Засаг дарга түүний Тамгын газарт хугацаатай үүрэг, чиглэл өгөх, сонсголын үр дүн хийсэн ажил, авсан арга хэмжээг тодорхой хугацааны дараа иргэдэд мэдээлнэ гэх мэт.

2.

Тэмдэглэл хөтлөх: Сонсох ажиллагааны үед иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тэмдэглэл хөтлөх ажлын хэсэг байгуулж сонсгол зохион байгуулах ажлын хэсгээс давхар тэмдэглэл хөтлөж аудио болон бичгэн хэлбэрээр тухайн байгууллагын албан ёсны цахим хуудсанд ажлын 7 хоногийн дотор байршуулна.

Төсвийн хяналтын сонсголын үр дүнд хяналт тавих:

1. Сонсголын үед хийгдсэн тэмдэглэл ба аудио бичлэгийг олон нийтэд хүргэх;
2. Нутгийн төлөөллийн ба захиргааны байгууллагаас иргэдэд үр дүнг мэдээлдэг болоход нөлөөлөх
3. Сонсголд оролцогч иргэд, Төрийн болон төрийн бус байгууллагууд сонсголын үр дүнд гарсан өөрчлөлт, ахицыг хянах
4. Төсвийн хяналтын сонсголыг жил бүр зохион байгуулах, үүргээ биелүүлээгүй бол нутгийн төлөөллийн болон захиргааны байгууллагыг Захиргааны хэргийн шүүхэд өгөх үнэдслэл бий.